


ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/035/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/035/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ТОНХИЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.ЦЭНД-АУЮШ ТАНАА

2025.02.21 № 61

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 16,320.4 мянган төгрөг хасагдаж орлогоо бүрэн төвлөрүүлээгүй,

8225020155

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн гүйцэтгэлийн дүн, төсвийн хэлбэлзэлийн тайлангаас 10,380.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
3. Хандив тусламжаар 27,102.5 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авахдаа акт баримт үйлдээгүй,
4. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлээрх хөрөнгийг тооцоо бодож баталгаажуулаагүй,
5. Тайлант онд хувь хүний орлогын албан татварын 27,024.9 мянган төгрөгийг шилжүүлээгүй. өглөгөөр тайлагнаагүй,
6. Өр төлбөрөөр тайлагнасан 4,067.4 мянган төгрөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй,
7. Цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 3,229.7 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
8. Ээлжийн амралтын мөнгөн олговор 1,072.2 мянган төгрөгийг цалинтай давхардуулсан, ээлжийн амралтын мөнгөн олговор 2,606.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
9. Үнэ төлбөргүй олгосон 316.2 мянган төгрөгийн бараа материал, 503.1 мянган төгрөгийн эм боох материалыг орлого аваагүй ,
10. Засаг даргын захирамжгүй эрүүл мэндийн төвийн даргад 1,831.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн төв 2024 онд давхардсан тоогоор 5213 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны хязгаарыг 27 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр 27 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт өмнөх оноос 254,120.7 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо өссөн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний тохолдолд суурилсан төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 163,820.8 мянган төгрөгийн нэхэмжилснээс 147,500.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч, 16,320.4 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилт 46 арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	166,768.9	168,230.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	371,804.7	344,167.6
	Нийт хөрөнгийн дүн	538,573.6	512,398.2
	Нийт өр төлбөрийн дүн	814.8	9,113.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	537,758.8	503,285.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	538,573.6	512,398.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	654,402.6	902,753.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	724,191.5	935,912.7
	Үйл ажиллагааны үр дүн	(69,788.8)	(33,159.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(5,000.0)	(978.5)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(74,788.8)	(34,137.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,547.7	537,758.8
	Тайлант оны үр дүн	(74,788.9)	(34,137.7)
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(335.9)
	Эцсийн үлдэгдэл	537,758.8	503,285.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	598,939.8	811,723.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	668,151.4	847,643.6
	Үйл ажиллагааны ЦМГ	(69,211.6)	(35,919.7)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(12,989.7)	(4,000.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(82,201.3)	(39,919.7)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	127,460.9	45,259.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,259.5	5,339.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	899,785.5	850,626.6
	Урсгал зардал	899,785.5	850,626.6
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	899,785.5	810,706.8
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	789,148.6	746,276.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,377.4	64,360.4
	Туслах үйл ажиллагааны орлого		70.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	45,259.5	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй нийт 51,032.8 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар 51,032.8 мянган төгрөгийн 11 зөрчил илэрч, 3,678.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 47,354.1 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 1 зөвлөмж, өгсөн.

Төлбөрийн акт

Ээлжийн амралтын мөнгөн олговор 1,072.2 мянган төгрөгийг цалинтай давхардуулсан, ээлжийн амралтын мөнгөн олговор 2,606.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам" 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" заалттай тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн гүйцэтгэлийн дүн, төсвийн хэлбэлзлийн тайлангаас 10,380.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Хандив тусламжаар 21,102.5 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авахдаа акт баримт үйлдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-т "Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ", Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/203 дугаар тушаалын хавсралт "Тусламж хандиваар эм, эмнэлэгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-т "Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, хандивын эм, эмнэлэгийн хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөнд бүртгэн авч, зарцуулалтад хяналт тавина"

гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив тусламж, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах комисс хүлээн авч байгууллагын даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлд авч, албан хаагчдад эд хөрөнгийн картаар эзэмшүүлэн, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд хувь хүний орлогын албан таварын 27.024.9 мянган төгрөгийг шилжүүлээгүй, өглөгөөр тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын хэлтэстэй тооцоо нийлж өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Өр төлбөрөөр тайлагнасан 4.067.4 мянган төгрөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай өр төлбөрийн тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

5. Цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 3,229.7 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлыг гүйлгэн зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. Үнэ төлбөргүй олгосон 316.2 мянган төгрөгийн бараа материал, 503.1 мянган төгрөгийн эм боох материалыг орлого аваагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-т Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ", Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/203 дугаар тушаалын хавсралт "Тусламж хандиваар эм, эмнэлэгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-т "Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөнд бүртгэн авч, зарцуулалтад хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Үнэ төлбөргүй ирсэн төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

7. Засаг даргын захирамжгүй ЭМТ-ийн даргад 1,831.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал авч буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 16,320.4 мянган төгрөг хасагдаж орлого төвлөрүүлэх боломжийг алдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт:

ГАА-2025/035/НА-СТА-ТШЗ

Жилийн эцсийн тооллогын бүртгэлээрх 1,042,020.2 мянган төгрөгийн хөрөнгийн тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллого хийж үр дүнг удирдлагын хэмжээнд хэлэлцэж тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		(мянган төгрөгөөр)				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын ЭМТ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		(мянган төгрөгөөр)									
			Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын ЭМТ	10	51,032.8	1	3,678.7	7	51,029.1	2		-	-	-	-
Дүн	10	51,032.8	1	3,678.7	7	51,029.1	2		-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

ГАА-2025/035/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		(мянган төгрөгөөр)					
			Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тонхил сумын ЭМТ	1	-	-	-	1	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1					1	
	НИЙТ		1					1	